



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2023/39/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2023 .02.17.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
Аудитын менежер А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: [tseenyama@audit.gov.mn](mailto:tseenyama@audit.gov.mn)  
“Глобаль капитал аудит” ХХК-ын захирал Д.Энхтуяа  
Утас: 89499922 Цахим хаяг: [enkhtuyad@gmail.com](mailto:enkhtuyad@gmail.com)  
Аудитор Д.Цэцэгмаа  
Утас: 88089024 Цахим хаяг: [tsetsegmaa\\_1961@yahoo.com](mailto:tsetsegmaa_1961@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	19
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

БУУЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.ГЭРЛЭЭ ТАНАА

2023.02.16 № 2/27  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д Орой, эчнээ, албан бус хэлбэрээр иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ гэсний дагуу Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.03.02-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг шинэчлэн баталснаар БШУ-ны сайдын 2022.05.12-ны А/170 тушаалаар "Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал"-ыг баталсан байна.

Дээрх өөрчлөлттэй холбоотойгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг санхүүжилтийн эх үүсвэрээс хамааран улсын төсвийн, орон нутгийн төсвийн гэж тайлагнан Сангийн яамны e-balance.mof.gov.mn системд шивж оруулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>68,978,733.79</u></b>	<b><u>77,379,955.47</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	2,179,771.64
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	2,179,771.64
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	2,179,771.64
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,179,771.64
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	12,599.96	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,599.96	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	68,966,133.83	75,200,183.83
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	68,966,133.83	75,200,183.83
35410	Бичиг хэргийн материал	614,600.00	699,600.00
35420	Аж ахуйн материал	25,032,869.28	25,032,869.28
35460	Хүнсний материал	2,124,750.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	41,193,914.55	49,467,714.55
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,161,385,469.86</u></b>	<b><u>1,118,916,989.65</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,161,385,469.86	1,118,916,989.65
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,131,985,469.86	1,089,516,989.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,185,101,395.76	1,185,101,395.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-119,536,319.40	-159,846,842.52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,188,487.25	85,073,687.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,643,809.32	-40,452,024.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,903,413.80	31,263,413.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,434,997.23	-16,029,938.75
39217	Ном	4,407,299.00	4,407,299.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	29,400,000.00	29,400,000.00
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-150,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,230,364,203.65</u></b>	<b><u>1,196,296,945.12</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,156,300.00</u></b>	<b><u>973,259.53</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,156,300.00	973,259.53
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,156,300.00	973,259.53
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,156,300.00	973,259.53
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,228,207,903.65</u></b>	<b><u>1,195,323,685.59</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,228,207,903.65	1,195,323,685.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,876,104.00	118,876,104.00

**Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

51101	Өмч: - төрийн	118,876,104.00	118,876,104.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>890,835,013.25</b>	<b>857,950,795.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	890,835,013.25	890,835,013.25
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-32,884,218.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	218,496,786.40	218,496,786.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,230,364,203.65</u></b>	<b><u>1,196,296,945.12</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>457,055,845.00</b>	<b>537,672,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,490,000.00</b>	<b>9,095,200.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,490,000.00</b>	<b>9,095,200.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ	5,400,000.00	9,095,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ	3,090,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>448,565,845.00</b>	<b>528,577,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>395,908,200.00</b>	<b>467,112,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	467,112,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395,908,200.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,252,840.00</b>	<b>00.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,252,840.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>38,404,805.00</b>	<b>61,464,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,404,805.00	61,464,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>463,037,516.40</b>	<b>570,557,118.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>463,037,516.40</b>	<b>570,557,118.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>447,316,102.39</b>	<b>569,066,270.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>281,055,319.00</b>	<b>344,035,874.85</b>
210101	Үндсэн цалин	281,055,319.00	344,035,874.85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>37,139,050.03</b>	<b>44,636,355.47</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,571,070.62	29,243,049.36
210202	Тэтгэмжийн даатгал	7,358,060.43	4,968,953.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,276,016.50	2,784,755.31
210204	Ажилгүйдлийн даатгал	539,559.43	694,508.83
210205	Эрүүл мэндийн даатгал	5,394,343.05	6,945,088.85

**Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,061,105.00	45,440,209.53
210301	Гэрэл, цахилгаан	2,797,905.00	4,737,159.53
210302	Түлш, халаалт	36,263,200.00	39,204,050.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,499,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,878,287.00	4,035,400.00
210401	Бичиг хэрэг	504,250.00	422,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,200.00	835,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,980,000.00	1,544,500.00
210404	Ном, хэвлэл	647,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,664,837.00	1,232,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	15,718,160.00	67,397,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	460,060.00	00.00
210502	Хоол, хүнс	15,090,600.00	67,397,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	167,500.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,066,500.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,782,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,284,500.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	135,900.00	00.00
210702	Дотоод албан томилолт	135,900.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	407,000.00	668,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	450,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	218,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	52,854,781.36	62,351,780.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,701,000.00	5,323,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,509,100.00	3,314,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,644,681.36	53,713,680.21
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,721,414.01	1,490,848.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,398,440.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,252,840.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	145,600.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	1,490,848.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,490,848.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,322,974.01	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,322,974.01	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-5,981,671.40</b>	<b>-32,884,218.06</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-5,981,671.40</b>	<b>-32,884,218.06</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>448,565,845.00</b>	<b>528,577,700.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>448,565,845.00</b>	<b>528,577,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	395,908,200.00	467,112,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	467,112,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395,908,200.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,252,840.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,252,840.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	38,404,805.00	61,464,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,404,805.00	61,464,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>448,565,845.00</b>	<b>524,247,928.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>448,565,845.00</b>	<b>524,247,928.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>432,844,430.99</b>	<b>522,757,080.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	280,213,615.00	345,166,452.67
210101	Үндсэн цалин	213,988,622.00	248,537,746.82
210102	Нэмэгдэл	34,827,104.00	70,282,649.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,880,000.00
210104	Урамшуулал	31,397,889.00	9,282,432.85
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	11,183,624.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,157,960.99	43,493,177.69
210201	Тэтгэврийн даатгал	26,770,597.58	28,840,732.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,847,706.43	4,228,092.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,276,016.50	2,784,755.31
210204	Ажилгүйдлийн даатгал	568,211.43	694,508.83
210205	Эрүүл мэндийн даатгал	5,695,429.05	6,945,088.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37,904,805.00	46,815,750.00
210301	Гэрэл, цахилгаан	2,797,905.00	3,956,400.00
210302	Түлш, халаалт	34,106,900.00	41,360,350.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,499,000.00

**Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,047,600.00	00.00
210401	Бичиг хэрэг	731,100.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,962,200.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,740,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	516,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	197,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,900,900.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,485,210.00	65,080,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	617,060.00	00.00
210502	Хоол, хүнс	17,215,350.00	65,080,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	652,800.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,070,453.00	500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,997,153.00	00.00
210602	Тавилга	2,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,273,300.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	135,900.00	00.00
210702	Дотоод албан томилолт	135,900.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,255,450.00	1,258,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	665,450.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	1,258,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,573,437.00	20,443,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,300,000.00	16,746,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,273,437.00	3,696,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,721,414.01</b>	<b>1,490,848.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	14,398,440.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,252,840.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	145,600.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	1,490,848.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,490,848.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,322,974.01	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,322,974.01	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>4,329,771.64</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>2,150,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>2,150,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	2,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,150,000.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	<u>-2,150,000.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,179,771.64
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,179,771.64

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	896,816,684.65	1,234,189,575.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	896,816,684.65	1,234,189,575.05
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,981,671.40	-5,981,671.40
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	890,835,013.25	1,228,207,903.65
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	890,835,013.25	1,228,207,903.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	890,835,013.25	1,228,207,903.65
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-32,884,218.06	-32,884,218.06
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	857,950,795.19	1,195,323,685.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	528,577,700.00	524,907,080.36	3,670,619.64	99.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,577,700.00	524,907,080.36	3,670,619.64	99.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,577,700.00	524,907,080.36	3,670,619.64	99.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,048,600.00	345,166,452.67	3,882,147.33	98.89
210101	Үндсэн цалин	273,801,600.00	248,537,746.82	25,263,853.18	90.77
210102	Нэмгдэл	57,156,900.00	70,282,649.00	-13,125,749.00	122.96
210104	Урамшуулал	5,190,300.00	9,282,432.85	-4,092,132.85	178.84
210105	Гэрээт ажлын хөлс	12,899,800.00	11,183,624.00	1,716,176.00	86.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,642,400.00	43,493,177.69	1,149,222.31	97.43
210201	Тэтгэврийн даатгал	30,356,800.00	28,840,732.48	1,516,067.52	95.01
210202	Тэтгэмжийн даатгал	3,571,400.00	4,228,092.22	-656,692.22	118.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,857,100.00	2,784,755.31	72,344.69	97.47
210204	Ажилгүйдлийн даатгал	714,300.00	694,508.83	19,791.17	97.23
210205	Эрүүл мэндийн даатгал	7,142,800.00	6,945,088.85	197,711.15	97.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,441,200.00	46,815,750.00	-1,374,550.00	103.02
210301	Гэрэл, цахилгаан	4,737,200.00	3,956,400.00	780,800.00	83.52
210302	Түлш, халаалт	39,204,000.00	41,360,350.00	-2,156,350.00	105.50
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,499,000.00	1,000.00	99.93
2105	Нормативт зардал	65,080,700.00	65,080,700.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	65,080,700.00	65,080,700.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,258,000.00	1,258,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,258,000.00	1,258,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22606800.00	22593000.00	13,800.00	99.94

**Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,106,800.00	18,106,600.00	200.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,500,000.00	4,486,400.00	13,600.00	99.70
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	528,577,700.00	527,086,852.00	1,490,848.00	99.72
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	467,112,900.00	467,112,900.00	0.00	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	467,112,900.00	467,112,900.00	0.00	100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	61,464,800.00	59,973,952.00	1,490,848.00	97.57
132001	Орон нутгийн төсвөөс	61,464,800.00	59,973,952.00	1,490,848.00	97.57
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	28.00	27.00	1.00	96.43
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	18.00	1.00	96.43
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.00	100.00
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	203.00	175.00	28.00	86.20
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	203.00	175.00	28.00	86.20

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бууцагаан сумын Цэцэрлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд зааснаар “бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж зорилго зорилтыг тодорхойлсон байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар :

- Засгийн газрын 2021.12.21-ны 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсан
- Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан хувьсах зардлын дундаж норматив, аргачлал
- БШУ-ны сайдын 2022 оны “Заавар батлах тухай “ А/170 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын тоног

төхөөрөмж, хэрэглэгдэхүүний нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх заавар аргачлал “

- БШУ-ны сайд, ЭМС-ын 2022 оны А/235, А/340 дугаар хамтарсан “Багшийн эрүүл мэндийн талаар авах арга хэмжээний тухай тушаал
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолууд
- БШУ-ны сайдын 2022 оны А/430 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам,
- БШУ-ны сайдын 2022 оны А/500 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал олгох журам

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д зааснаар Цэцэрлэгийн хувьсах зардлаар тооцсон зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой 2022 оны 12 дугаар сарын 31-нээрхи санхүүгийн тайланг БШУЯ-ны БЕГ-т нэгтгэгдэж, орон нутгийн ТЕЗ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдээгүй, Сангийн яамны Э-тайланд хөрөнгө шилжүүлэн тайланг гаргаж, орон нутгийн тайлан эхний үлдэгдэлтэй эцсийн үлдэгдэлгүй, Улсын төсвийн тайланд эцсийн үлдэгдлээр тайланг нэгтгэсэн байна.

Дотоод хяналтыг ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт дотоод аудитын алба хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Баянхонгор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,196,296.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 34,067.3 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	68,978.7	77,380.0	8,401.2
Мөнгөн хөрөнгө	-	2,179.8	2,179.8
Авлага	12.6	-	(12.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	68,966.1	75,200.2	6,234.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,161,385.5	1,118,917.0	(42,468.5)
Үндсэн хөрөнгө	1,324,150.6	1,335,395.8	11,245.2
Хуримтлагдсан элэгдэл	(162,765.1)	(216,478.8)	(53,713.7)
<b>Нийт хөрөнгө</b>	1,230,364.2	1,196,296.9	(34,067.3)
Өр төлбөр	2,156.3	973.3	(1,183.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,228,207.9	1,195,323.7	(32,884.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	1,230,364.2	1,196,296.9	(34,067.3)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,179.8 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 75,200.2 мянган төгрөг болж 6,234.1 мянган төгрөгөөр өссөн нь нь тайлант хугацаанд нийт 79,002.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 72,768.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан ба бусад хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 8,173.8 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,335,395.8 мянган төгрөг болж 11,245.2 мянган төгрөгөөр өссөн нь БШУ-ны сайдын 2022.11.23-ны “Журам батлах тухай” А/488 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ын хүрээнд Боловсролын ерөнхий газраас 2,273.8 мянган төгрөгийн үнэтэй 4 ш зөөврийн компьютер нийлүүлэгдсэн, аймгийн БШУГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, “Шимт

боловсрол" ХХК-ийн захирал , Бууцагаан сумын цэцэрлэгийн эрхлэгч нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээ 2022.11.25-ний ШБ/22/33-тоот гэрээгээр 2,150.0 мянган төгрөгөөр тавилга, эд хогшил худалдан авсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,195,323.7 мянган төгрөг болж 32,884.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант хугацаанд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын санхүүжилтээр бүрэн санхүүжүүлэхээр 30 орон тоотойгоор 277 хүүхдийг хамруулахаар нийт зарлагыг 717,090.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 162,388.3 мянган, нормативт зардлыг 54,124.7 мянган, урсгал шилжүүлгийн зардлыг 25,898.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 439,110.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативаар тооцож төсвийг хуваарилсан, төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн зардал, боловсролын байгууллагуудын ажилтнуудад улирал тутам олгодог үр дүнгийн урамшуулал олгох хэлбэр зэрэгт өөрчлөлт орсонтой холбоотой байна.

Тайлант хугацаанд тус цэцэрлэгийн төсвийн хуваарьт 2022 оны 12 дугаар сард өөрчлөлт орж, улсын төсвөөс авах санхүүжилтийг 528,577.7 мянган төгрөгөөр , орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 61,464.8 мянган төгрөгөөр буюу нийт зарлагыг 439,068.7 мянган төгрөгөөр баталжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхэд 528,577.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 462,112.9 мянган төгрөгийн, тогтмол зардлын санхүүжилтэнд 61,464.8 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар батлагдсаныг бүрэн авсан байна.

Тайлант оны батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524,907.1 төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь тогтмол зардлын санхүүжилтээс зарцуулаагүй үлдэгдлийн 1,490.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн, улсын төсвөөс олгосон санхүүжилтээс 2,179.8 мянган төгрөгийг зарцуулаагүй, мөнгөн хөрөнгө дансанд үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 71801- Сургуулийн өмнөх боловсрол	528.577.7	524.907.1	3,670.6	99.3
АРГА ХЭМЖЭЭ 80112 –Нийтлэг үйлчилгээ	61,464.8	59,973.9	1,490.8	97.6
АРГА ХЭМЖЭЭ 81605- Эрүүл мэндийг дэмжих	1,700.0	1,700.0	0.00	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	65,080.7	65,080.7	0,00	100.0
АРГА ХЭМЖЭЭ 81816- Хүүхдэд эзлтэй сургалтын орчин	1,926,8	1,926.8	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81823- Боловсролын байгууллагын багш,	1,700.0	1,700.0	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 81834- Боловсролын стандарт, сургалт	350,111.2	348,320.8	1,790.4	99.5
АРГА ХЭМЖЭЭ 81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	39,094.2	38,704.9	389.3	99.0
АРГА ХЭМЖЭЭ 83601- Нэмэлт-бараа үйлчилгээний бусад зардал	7,500.0	7,500.0	0.0	100

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Глобал капитал аудит” ХХК-нийн аудитор Д.Энхтуяа, Д.Цэцэгмаа нар 2023 оны 1 дүгээр сарын 25-наас эхлэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 06-ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсөвт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг завсрын аудит хийх явцад анхны батлагдсан төсөвт зардлын 439,068.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,586.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0%-иар тооцон 4,939.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийн хүрээнд 528,577.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, батлагдсан төсвөөс нийт 3,670.6 мянган төгрөгийг хэмнэснээс хуульд хамаарах зардлыг батлагдсан хэмжээнд нь зарцуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаатай холбоотой 65,080.7 мянган төгрөгийн 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 485,304.5 мянган төгрөгийн 28 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 46,015.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 42,837.6 мянган төгрөгийн 11 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийссэн ба завсрын аудитаар зөрчил, дутагдал илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 11,306.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 4,615.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 6,691.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг хугацаанд нь хэрэгжүүлж хэрэгжилтийн тайланг 2022.02.28-ний өдрийн 28 дугаар албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж, Fas программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна. байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4,615.1	1	4,615.1	100
Төлбөрийн акт	1	6,691.5	1	6,691.5	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>11,306.6</b>	<b>2</b>	<b>11,306.6</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бууцагаан сумын Цэцэрлэгийн дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,513.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоож, хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж байх 1 зөвлөмж хүргүүлэв.

##### 5.1 Төлбөрийн акт

1. Багш ажилтнуудад түлшний хөнгөлөлтын зардлын төсөв батлагдаагүй байхад эрхлэгчийн 2022.12.14-ний өдрийн Б/42 тоот тушаалаар ажилтнуудад өдрийн 10,0 мянган төгрөгөөр тооцон нэг ажилтанд 210,0 мянган төгрөгийн, нийт 5,880.0 мянган төгрөгийн түлшний үнийн хөнгөлөлтийг 11,12-р сарын цалин дээр нэмж цалингийн зардлаас олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2021.10.29-ний 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан

зардлын эдийн засгийн ангиллыг зөрчсөн, Санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажилтнуудад олгосон 12 дугаар сарын түлшний үнийн хөнгөлөлтийн 5,880.0 мянган төгрөгийг суутган тооцож төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. 2022 оны 8-р сард нэг ажилтанд 1000.0 сая төгрөгийн урьдчилгаа олгоод 366.6 мянган төгрөгийг суутгаж үлдэгдэл 633.4 мянган төгрөгийг суутгаагүй байхад авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2.”бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажилтанд олгосон цалингийн урьдчилгааг дутуу суутгаад авлагаар бүртгээгүй 633.4 мянган төгрөгийг холбогдох ажилтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

## 5.2.Зөвлөмж

1. Цэцэрлэгийн төсвийн менежер нь цалингийн зардлаас төсөвт тусгагдаагүй байхад түлшний хөнгөлөлт олгох шийдвэр гаргаж 2022 онд 2 удаа нийт ажилтнуудад олгосон ба энэ зөрчил арилахгүй 2020-2022 онуудад давтагдан гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай " Сангийн сайдын 2021.10.29-ний 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчсөн, Санхүүгийн тайлагналын “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Цаашид төсөвт батлагдаагүй байхад зардлын эдийн засгийн ангиллыг зөрчиж цалингийн зардлаас түлшний үнэ олгож, зөрчил дутагдал давтан гарч байгааг таслан зогсоох

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

**Бууцаган сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

1.Цэцэрлэгийн төсвийн менежерийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний Б/42 дугаар тушаалаар цалингийн зардлаас төсөвт тусгагдаагүй байхад ажиллагсадад түлшний хөнгөлөлт олгох шийдвэр гаргаж 2022 оны 11, 12-р саруудад 28 ажилтанд 5,880,000 төгрөгийг 2 удаа нийт 11,760,000 төгрөг олгосноос 11-р сард олгосон түлшний үнийн хөнгөлөлтийн шийдвэр 12-р сард гарсан байна.	3	5,880.0	1	5,880.0			1	0,00				
2. 2022 оны 8-р сард 1 ажилтанд 1000.0 сая төгрөгийн урьдчилгаа олгоод 366.6 мянган төгрөгийг суутгаж үлдэгдэл 633.4 мянган төгрөгийг суутгаагүй байхад авлагаар бүртгээгүй байна.	1	633.4	1	633.4								
<b>ДҮН</b>	<b>3</b>	<b>6,513.4</b>	<b>2</b>	<b>6,513.4</b>			<b>1</b>	<b>0,00</b>				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 23/14425182

БНН-2023/39/НА-СТА-7УС

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант 2022 оны 8-р сард нэг ажилтанд 1,000,00 төгрөгийн урьдчилгаа олгоод 633,433 төгрөгийг суутгаагүй авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2. "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5. бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтан Гэрлээгээр дутуу суутгасан урьдчилгаа цалингийн 633,433 /Зургаан зуун гучин гурван мянга дөрвөн зуун гучин гурван/ төгрөгийг төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Гэрлээ, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

6417143544

БЧОА0067 9007423

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

005050068



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 24/14425182  
БНА-2023/39/НА-СТА-Т143

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэгийн төсвийн менежерийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний Б/42 дугаар тушаалаар цалингийн зардлаас төсөвт тусгагдаагүй байхад ажиллагсадад түлшний хөнгөлөлт олгох шийдвэр гаргаж 2022 оны 11, 12-р саруудад 28 ажилтанд 5,880,000 төгрөгийг 2 удаа нийт 11,760,000 төгрөг олгосоноос 11-р сард олгосон түлшний үнийн хөнгөлөлтийн шийдвэр 12-р сард гарсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, "тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" Сангийн сайдын 2021.10.29-ний 190 тоот тушаалын хавсралтаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5 бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн, 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль, тогтоомж зөрчиж 11-р сард шийдвэргүй олгосон түлшний үнийн хөнгөлөлт 5,880,000 /таван сая найман зуун наян мянган/ төгрөгийг хавсралтад дурдсан нэр бүхий 28 ажилтнаар төлүүлж, Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх<sup>1</sup>

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Гэрлээ, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт хариуцуулав<sup>2</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ  
"ГЛОБАЛ КАПИТАЛ АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР Д.ЦЭЦЭГМАА

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно